

“БӨХӨГ” ХК-ИЙН 2018 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2018 оны 04-р сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

Монгол улсын компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1, 69-р зүйлийн 69.1 дэх заалт болон “Бөхөг” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.А хэсгийн заалтуудыг тус тус удирдлага болгох Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ын тогтоолын дагуу “Бөхөг” ХК-ийн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04-р сарын 29-ний өдрийн 10 цаг 00 минутанд Хан-Уул дүүргийн 13-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “Бөхөг” ХК-ийн хурлын танхимд эхлэв.

Хуралд бүртгэлийн өдөр бүртгүүлсэн хувьцаа эзэмшигчид болох Ц.Чанцал, Ц.Ганцэцэг, Э.Гэрэлт-Одыг итгэмжлэлээр төлөөлж Ц.Чанцал, Д.Эрдэнэцогт, БиДиСек-ыг итгэмжлэлээр С.Дамдинсүрэн, Тооллогын комиссын гишүүд болох М.Баасансүрэн, Д.Отгонжаргал, Ц.Алтантогос ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга М.Билгүүнзаяа нар оролцов.

2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг компанийн ТУЗ-ийн гишүүн Цогт овогтой Чанцал даргалав.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Юуны өмнө Монгол улсын компанийн тухай хуулинд заасны дагуу зарласан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хуралдаа идэвхитэй оролцохыг хүсье. Өнөөдрийн хуралд компанийн нийт энгийн хувьцааны 151307 ширхэг хувьцааг эзэмшигч Ц.Чанцал, 118906 ширхэг хувьцааг эзэмшигч Ц.Ганцэцэг, 150906 ширхэг хувьцааг эзэмшигч Э.Гэрэлт-Од /Япон улсад удаан хугацаагаар амьдарч байгаа/-ыг итгэмжлэлээр төлөөлж Ц.Чанцал, 5107 ширхэг хувьцааг эзэмшигч Д.Эрдэнэцогт, БиДиСек-ыг төлөөлж итгэмжлэлээр С.Дамдинсүрэн нар оролцож хурлын ирц 94.76 хувьтай байна. Иймээс 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “ХЭХ” гэх/-ыг хуралдуулж байна. Миний бие ТУЗ-ийн Тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар томилогдсон учир хурлын үйл ажиллагааг удирдаж байгаа болно. Өнөөдрийн хурлаар бид дараахь асуудлыг хэлэлцэхээр оруулж ирж байна. Энэ талаар Хурлын зар гаргахдаа нийт хувьцаа эзэмшигчдэдээ мэдээлсэн болно.

Үүнд:

- i. Компанийн 2016-2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,
- ii. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах,
- iii. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах,
- iv. Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэж ТУЗ-д эрх олгох эсэх,
- v. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан тогтоолыг хэлэлцэж батлах,
- vi. Бусад

Мэдээлэл сонссны дараа асуулт, хариулт, саналаа хэлээд батлаад явна.

Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:

1. Компанийн 2016-2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах

Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе. 2017 он хийсэн ажлын тайлангаа танилцуулав.

2017 оны хувьд хөрөнгө оруулалт, санхүүжилтгүй, үйлдвэрлэлийн үйл ажиллагаа бүрэн зогссон жил байсан. Хөрөнгө оруулалт, санхүүжилт олох зорилгоор холбогдох

газруудаас зарласан тендер, төслийн сонгон шалгаруулалтанд оролцож материалуудаа хүргүүлж ажилласан. Мөн япон, германаас хөрөнгө оруулалт хүссэн. Герман бол татгалзсан хариу өгсөн. Япон бол судалж байгаа гэсэн хариу өгсөн. Гадаадын олон улсын байгууллагууд их удаан хугацаанд судалж байна гэсэн хариу өгдөг. Их нарийн судалж байж хөрөнгө оруулалт хийдэг юм байна. Үйл ажиллагааны талаар асуух асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Байхгүй.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Германы талаас хөрөнгө оруулалт татгалзсан хариу өгсөн юм байна. Өөр хөрөнгө оруулагч судалж хайх ажил хийгдсэн үү?

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Эхлээд Герман улсын хөрөнгө оруулагч уулзаж судлуулахад татгалзсан. Дараа нь Япон улсын хөрөнгө оруулагчтай уулзалт хийж материалуудаа өгсөн. Одоо хариу ирэхийг хүлээж байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Япон улсаас ямар чиглэл, нөхцөлөөр хөрөнгө оруулалт хийх талаар ярьсан юм байна уу?

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Судлаж л байгаа. Япончууд судалсны эцэст ямар чиглэлээр ямар нөхцөлөөр хэдий хэмжээний хөрөнгө оруулалт оруулахыг бид мэдэх боломжгүй. Судалж байснаа хөрөнгө оруулалт хийх боломжгүй гэхийг бас үгүйсгэхгүй. 2012 оноос хойш дотоодын банкуудад хандаж зээл хүссэн боловч хүү өндөр, богино хугацаатай байдаг, зээлийн хэмжээ бага тул боломжгүй болсон. Дотоодоос хөрөнгө оруулалт олдохгүй, гадаадынхан хөрөнгө оруулалт хийх сонирхолгүй болсон юм байна. Яагаад гэвэл манай улсын хэмжээнд эдийн засаг их тогтворгүй байгаагаас болж байна. 2015 оноос эхлэн гадаадын хөрөнгө оруулалт олохоор шийдвэрлэн олон улсын шувууны бизнес эрхлэгчдийн форумд манайхыг төлөөлөн Япон улсад хувьцаа эзэмшигч Гэрэлт-Од, Чанцал, АНУ-д хувьцаа эзэмшигч Чанцал, Амарбаяр нар оролцож байгууллагаа сурталчилах ажлыг хийсэн. Үүний дараа манайхыг 2 улсаас хөрөнгө оруулалт хийх зорилгоор судалж үзэхээр шийдвэрлэсэн. Бизнес төлөвлөгөө англи, монгол хэл дээр хийгдсэн. Шувууны аж ахуй бол багахан хэмжээний эргэлтийн хөрөнгөөр үйл ажиллагааг эхлүүлэх юм бол буцаад зогсонги байдалд орох эрсдэлтэй эргэлтийн хөрөнгө ихтэй эхлүүлэхгүй бол шувуундаа 1 өдөр мөнгөгүй байна хоол өгөхгүй хонуулая гэсэн зүйл огт байхгүй. Тасралтгүй үйлдвэрлэл явуулахад эргэлтийн хөрөнгө их хэрэгтэй байдаг бизнес юм.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За саяны яригдсан зүйлүүдтэй холбоотой өөр асуух асуулт байна уу?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Би өр төлбөрийн харьцааг мэдэж болох уу?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Болно. Та жилийн эцсийн санхүүгийн тайлантай танилцана уу. Өр төлбөрийн хувьд бол компанийг анх авахад 2 тэрбум 50 сая төгрөгний өртэй байсан. Үүнээс 50-60 хувь буюу 1,5 тэрбум төгрөгийн өрийг барагдуулсан. Цаашид газрын төлбөрийг төлж өр төлбөргүй болгохоор төлөвлөн ажиллаж байна. Хөрөнгө оруулалт орж ирэхэд газар хамгийн чухал шүү дээ.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Өндөгний үйлдвэрлэл явуулдаг компани шүү дээ. НВЦ, түмэн шувуут зэрэг өрсөлдөгч байгууллагын судалгаа хийгдсэн үү?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Бизнес төлөвлөгөөнд өрсөлдөгч байгууллагын судалгаа хийгдсэн байгаа. Манай төлөвлөгөө нь 500000 толгой өндөглөгч тахиа буюу 12,6 тэрбум төгрөгний өртөгтэй хийгдсэн. Энэ нь нийт өндөгний зах зээлийн 60-70%-ийг хангана гэж үзэж байгаа. НВЦ 110000 толгой өндөглөгч тахиа, түмэн шувуут 130000 толгой өндөглөгч тахианы хүчин чадалтай гэж нийтэд мэдээллэсэн байсан. Манай одоогийн тоног төхөөрөмж нь Чех улсынх, хүчин чадал нь 60000 толгой өндөглөгч тахиа байгаа. Энэ тоног төхөөрөмжөөр үйл ажиллагааг эхлүүлэх гэхээр энэ нь хуучирсан тоног төхөөрөмж бөгөөд гар ажиллагаа маш ихтэй үүнийг дагаад зардал өснө гэж тооцсон. Мөн ус, дулаан, цахилгааны үнэ сүүлийн 4-5 жилд өссөнтэй холбоотой үйл ажиллагааг эхлүүлээгүй. Үүнээс үүдэлтэй бизнесийн алдагдалд орохоос сэргийлсэн.

За компанийн 2016-2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах уу?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Тэгье зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Зөвшөөрч байна.

Үйл ажиллагааны тайлангийн талаар Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан Дүгнэлтийг баталъя гэв.

Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:

2. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах

Компаний үйл ажиллагаа зогссон байгаа тул 2018 оны ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан. Нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах боломжгүй байна. Үүнд:

- Удирдлага зохион байгуулалт – 7 ажил
- Үндсэн үйл ажиллагааны чиглэл – 12 ажил
- Хүний нөөцийн хөгжилийн чиглэл – 6 ажил
- Аж ахуйн чиглэл – 11
- Санхүүгийн чиглэл – 4 ажил тус тус төлөвлөсөнг танилцуулав.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Төлөвлөгөөтэй холбоотой нэг зүйл асууя. Тоног төхөөрөмж хуучнаас гадна барилга нь хуучирсан байгаа. Одоо хөрөнгө оруулалт орж ирлээ гэхэд барилга нь стандартын шаардлага хангаж байна уу?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Энэ тал дээр германуудын хэлж байгаагаар бол барилгыг шууд нурааж дахин шинээр төлөвлөж хийх тэгэхээр байгууллагад өмч гэдэг зүйл байхгүй болно тиймээс хөрөнгө оруулалтын шаардлага өндөр болно. Япончуудын хувьд барилга нь эртний боловч барилгыг нураахгүй ашиглаж болно гэж байгаа. Энэ асуудлын хувьд аль улс нь ямар өнцөгөөс харж байгаагаас шалтгаалж байна гэж үзэж байна. Ерөнхийдөө нэмэлтээр шинээр барилга барьж байж л тоног төхөөрөмжөө байрлуулан үйл ажиллагааг эхлүүлэх байх. Тухайн үед нь хэлцэлээ яаж хийхийг ТУЗ-д эрхийг нь олговол шийдвэрлээд явах байх.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Одоо бол ерөнхийдөө хөрөнгө оруулалтаа л хүлээж байгаа юм байна гэж ойлгож болох уу?

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Болно. Хариугаа л хүлээж байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За өөр асуух асуулт байна уу? Байхгүй бол 2018 оны төлөвлөгөөгөө батлах уу?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Тэгье.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Зөвшөөрч байна.

Компаний 2018 оны төлөвлөгөөг баталъя гэв.

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: ТУЗ-ийн дарга М.Норов нь 82 настай эрүүл мэндийн хувьд боломжгүй болсон тул өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлт гаргасан. Та бүхэн юу гэж бодож байна вэ?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Хүсэлтийг харгалзан үзэж чөлөөлөх нь зүйтэй байх. Нас сүүдэр өндөр болсон тул чөлөөлөхийг дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Дэмжиж байна. ТУЗ-ийн дарга гэдэг чинь эрч хүчтэй хөдөлгөөнтэй хүн байх хэрэгтэй. Их хэмжээний хэлцэл хийх зэргээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай уулзах шаардлага их гардаг шүү дээ. ТУЗ-ийн даргыг чөлөөлвөл дараагийн даргыг томилох хэрэгтэй. Миний хувьд Чанцалыг ТУЗ-ийн даргаар томилох хүсэлтэй байна.

Хувьцаа эзэмшигч Э.Гэрэлт-Од-г Ц.Чанцал: Гэрэлт-Од бичгээр саналаа над руу явуулсанг танилцуулья.

Эрхэм хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга, хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэж, хуралд нь амжилт хүсье.

Миний бие хувьцаа эзэмшигч Э. Гэрэлт-Од нь гадаад улсад ажиллаж байгаатай холбогдуулан хувьцаа эзэмшихтэй холбоотой бүх эрхийг Ц.Чанцалд итгэмжлэлээр олгосон болно.

Хурлын бүх материал болон хэлэлцэх асуудалтай уншиж танилцаад өөрийн зарим саналыг бичгээр хүргүүлж байна.

1. Компанийн үйл ажиллагааг идэвхижүүлж хөрөнгө оруулагчдыг татах үйл ажиллагааг зөв зохион байгуулах

2. ТУЗ болон гүйцэтгэх захиралын идэвх санаачлагатай ажиллахыг шаардах. Шаардлагатай бол өөрчлөх

3. Нэмэлт хувьцаа гаргах ажлыг түр зуур хойшлуулах эсвэл гаргахгүй байх Дэлхий нийтээр хувьцааны үнэ унаж байгаа үед их хэмжээний хувьцаагаар шаардлагатай хөрөнгө босгож чадахгүй байх эрсдэлтэй байна. Харин үүний оронд хөрөнгө оруулагчдыг татах ажлыг зохион байгуулах зүйтэй байна.

4. Хөрөнгө оруулалттай хобоотой их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгох 5.Хэрвээ шувууны аж ахуйн чиглэлээр цаашид явах боломжгүй бол компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг өөрчилж компанийг эхлүүлэн хөдөлгөх саналыг хүлээн авч, хэлэлцэн шийдвэрт тусгахыг хүсье.

Та бүхэнд сайн сайханыг хүсье.

Хүндэтгэсэн Бөхөг ХК-ийн хувьцаа эзэмшигч Э. Гэрэлт-Од 2018 он 4 сарын 24

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Миний хувьд бас Чанцалыг даргаар томилох хүсэлтэй байна. Эрч хүчтэй, шувууны аж ахуйн өргөн мэдлэгтэй гадаадын хөрөнгө оруулагчдад компанийн үйл ажиллагааг ойлгуулах мэдлэг чадвартай тул би дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За тэгвэл олонхийн саналаар Чанцалыг ТУЗ-ын даргаар томилох уу? Дэмжиж байна уу?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Дэмжиж байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Дэмжиж байна.

ТУЗ-ийн дарга М.Норовыг үүрэгт ажлаас чөлөөлж Ц.Чанцалыг ТУЗ-ийн даргаар томилов.

Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг:

4. Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэж ТУЗ-д эрх олгох эсэх

Яагаад шинээр нэмж хувьцаа гаргах гээд байгаа вэ гэхээр өмнөх жилийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал дээр ярьж байсанчлан компанийн үйл ажиллагааг өргөжүүлбэ, шинэ технологи нэвтрүүлэхэд санхүүгийн эх үүсвэр бий болгох зорилгоор нийт зарласан энгийн хувьцааны 20 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний энгийн хувьцааг 2018 оны 4-р улиралд багтаан нэмж гаргасугай гэсэн төсөл боловсруулсаныг юу гэж бодож байна. Хувьцаа эзэмшигч та бүхэн саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Нэмэлт хувьцаа гаргах асуудал хойшилж байгаа.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Миний бодлоор арай өөр аргаар буюу франчайзинг хийвэл ямар вэ? Бидэнд “Бөхөг” гэсэн үнэ цэнэтэй нэрээ жижиг компаниудад ашиглуулан өөрсдийн нэр хүндээ өсгөж ирээдүйн маркетингийн зардалаа хэмнэвэл ямар вэ? Жижиг 2 компани оруулан түгээлтийн зардалаа хэмнэх санал тавьж бас болох байх. Нэг бүтээгдэхүүний зардал буурвал тухайн байгууллагад ашиг нэмэгдэнэ, мөн манай компанид бас орлого олж ашигтай гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Үнэ цэнэтэй зөвөлгөө өгсөнд баярлалаа. Бид өмнө нь хувиараа шувууны аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг жижиг компаниуд,

хятадууд бас байраа түрээслэх санал тавьж байсан. Бөхөг компаний нэрийг ашиглан үйл ажиллагаа явуулж байгаад шувууны өвчин гарвал тухайн байгууллага гарсан үр дагаврыг хариуцахгүй гэж байсан. Үүнээс үүдэлтэй ямар типийн өвчлөлөөс шалтгаалан компаний үйл ажиллагааг 10 хүртэл жилээр зогсоодог юм байна. Арай гэж хөрөнгө оруулалт олоод авах гэтэл манай компанид өвчин гарсан байвал бидэнд хөрөнгө оруулах билүү? Ялангуяа хятад тахианы өвчлөл ихтэй байдаг юм байна лээ. Хэрэв өвчин гарвал 10 жил үйл ажиллагааг зогсоовол бид маш их эрсдэлд унах аюултай. Франчайзингийн талаар манай Худалдаа аж үйлдвэрийн танхим АНУ-ын Нью-Йорк хотод IV/28-IV/30-ны хооронд зохион байгуулж байгаа үзэсгэлэнд манай хувьцаа эзэмшигч Гэрэлт-Од оролцохоор бүртгүүлсэн байгаа. Энэ хүн маань цаашаа үргэлжлүүлэн Вашингтон хотод зохиогдох Шувууны холбооноос зохион байгуулж байгаа хүнсний эко бүтээгдэхүүний үзэсгэлэнд оролцохоор явна. Бид бүгд явах гэхээр зардал мөнгөнөөс эхлээд их хэцүү байна. Өмнө явсан үзэсгэлэн, яармагт компани орлогогүй тул бид хувийн зардалаар явсан. Уул нь хэлэлцэж ярилцаад 2-3 хүн төлөөлөгч болоод явбал их зүгээр байдаг юм. Тиймээс энэ удаа төлөөлөгчөөр Гэрэлт-Од явсан. Энэ удаагийн оролцсон хурал, үзэсгэлэнгийн талаар мэдээллийг бидэнд явуулна.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Нэмж хувьцаа гаргах эсэх тал дээр би чадах чинээгээрээ туслах боломжтой шүү. Би өөрөө эдийн засгийн чиглэлээр боловсрол эзэмшсэн наяд гээд хувьцааны сайт ажиллуулж байсан, 2007-2011 онд хувьцааны чиглэлээр бизнес хийж байсан. 2011 оноос хойш гадаадад амьдарч ирэн очин байсан. Энэ талаар мэдээллээр хангаж чадна шүү.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Бүгдээрээ хүчээ нэгтгэн компаний үйл ажиллагааг жигдрүүлхийг эрмэлзэн ажиллья.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Бид чинь хамаг хөрөнгөө л энэ компанид оруулсан учир энэ үйлдвэрээ ашиглахгүй байгаа он цагийн эрхээр барилга байгууламж, тоног төхөөрөмж муудаж үнэ цэнээ алдвал хэцүүдэх нь ээ.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Барилга байгууламж, тоног төхөөрөмж ашиглахгүй байсаар байгаад тоос шороонд дарагдаад элэгдэл хорогдол явагдаад муудаж байна. Тиймээс бүрэн цогцоор нь шинэчлэхгүй бол ганцхан байшин заслаа гэхэд нөгөө хуучин нь гологдох жишээний байна. Иймээс компанийг бүрэн шинэчилж байж л үйл ажиллагаагаа эхлэхгүй бол хий дэмий баахан хөрөнгөө оруулж компаниа аврах биш алах эрсдэлээс урьдчилан сэргийлж байна. Хувьцаа гаргах тал дээр ямар саналтай байна вэ? Гэрэлт-Одын саналыг уншиж танилцуулахад нэмж хувьцаа гаргаж удирдлагаа алдах эрсдэлд хүрэхвий гэсэн анхааруулгыг өгсөн байсан. Энэ хүн өөрөө япон улсад эдийн засгийн чиглэлээр боловсрол эзэмшсэн.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Одоо бол бага хэмжээний хувьцаа авч манай компанид орж ирэхгүй байх. Саналын эрхтэй хүн орж ирэх магадлал өндөр хяналтын эрхээ алдаж магадгүй.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Тиймээ. Би бас тэгж бодож байна. Тиймээс нэмж хувьцаа гаргахгүй байх саналтай байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Миний хувьд их хэмжээний биш юмаа гэхэд бага хэмжээний хувьцаа гаргах нь зүйтэй гэж бодож байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Нэмж хувьцаа гаргалаа гэхэд одоо үйл ажиллагаа зогссон байгаа тул орж ирж байгаа хувьцааны хөрөнгөөр үйл ажиллагаагаа бүтэн сэргээж чадахгүй. Хувьцаа гаргахаас илүү их хэмжээний хэлцэл буюу хөрөнгө оруулагчтай болох нь зүйтэй байх. Их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгоё гэсэн саналтай байна. Гэхдээ хувьцаа эзэмшигч бид нарыг хохируулахгүй байхыг сануулья.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Тэр нь зөв байх би бас их хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгох нь зүйтэй гэж үзэж байна. Хурдан хурдан ажиллах хэрэгтэй байх.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За тэгвэл нэмж хувьцаа гаргахаа түр хойшлуулаад, их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгоё гэж шийдвэр гаргах уу?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Зөвшөөрч байна.

5. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан тогтоолыг хэлэлцэж батлах

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: МУ-ын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэг "Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваариалх эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна." гэж заасан байдаг бөгөөд манай "Бөхөг" ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн 2018 оны 03-р сарын 06-ний өдрийн хурлаас "Бөхөг" Хувьцаат компанийг дахин хөрөнгөжүүлэх асуудал шийдвэрлэх боломжгүй байдлаас болж үйл ажиллагааны үндсэн чиглэл болсон

-шувууны аж ахуй эрхлэх,

-шувууны мах, өндөг бэлтгэх, борлуулах үйл ажиллагаа бүрэн зогссон. Үүнтэй холбоотойгоор орлого орохгүй болж ямар ч санхүүжилтгүй болсон, мөн бусдад төлөх их хэмжээний татварын, зээлийн болон бусад өр төлбөртэй байгаагаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах боломжгүй болохыг нийт хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй." гэсэн №02 тоот Тогтоол гарсан. Энэхүү шийдвэртэй холбогдуулан санхүүгийн тайлан болон бусад шаардлагатай баримт, материалуудыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахаар авчирсан байгаатай танилцана уу.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Үйл ажиллагаа явуулаагүй тул ногдол ашиг тараахгүй байх нь зүйтэй тул ТУЗ-ийн тогтоолын баталъя.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Зөвшөөрч байна. Яаж ногдол ашиг тараах билээ дээ.

6. Бусад

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Санхүүгийн зохицуулах хорооноос 2018.03.13-ны өдрийн 91952 тоот албан бичигт компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахыг үүрэн даалгавар болгон ирүүлсэн байна. Компанийн тухай хуулийн 94.2-т "Хувьцаат компанийн дүрэмд аудитын байгууллагыг заавал ажиллуулахаар заана" гэж заасантай нийцүүлэн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дүрэмдээ нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэж батлах. Мөн хуулийн 94.3-т "Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хороо аудитын байгууллагыг сонгож, түүнтэй байгуулах гэрээг батална, 94.4-т "Энэ хуулийн 94.3-д заасан гэрээнд компанийн болон аудитын байгуулллагын эрх, үүрэг, хариуцлага, аудиторт төлөх хөлсний хэмжээг заана гэсэн нэмэлт өөрчлөлттэй нийцүүлнэ гэсэн даалгавар ирсэн. Манай компанийн дүрэмд аудитын хороо байдаг. Ер нь бол өмнө жилүүдэд санхүүгийн зохицуулах хорооны сайтанд тавьсан зөвшөөрөлтэй компаниудаар жилийн эцсийн аудитын тайланг хийлгэж хуулбарын санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржэд хүргүүлж ажилладаг. Тиймээс энэ жил мөн адил зөвшөөрөл бүхий аудитын байгууллагыг сонгон төлөх хөлсний хэмээг батлах эрхийг ТУЗ-д нь олговол ямар вэ?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Тиймээ. Зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Хороонд бүртгэлгүй аудитын компаниар аудит хийлгэвэл хороо хүлээн зөвшөөрдөггүй тул сайн судалж байж сонгох хэрэгтэй. Тиймээ зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Дүрэмд дараах хэд хэдэн зүйл дээр нэмэлт өөрчлөлт оруулах саналтай байна. Компаний үйл ажиллагаа бүрэн зогссон байгаа тул цаашид бизнес төлөвлөгөөтэй холбоотой нэмэлт ажил хийгдэнэ. Түүний үйл ажиллагааны чиглэлийг дүрэмдээ нэмэлтээр тусгахгүй бол үйл ажиллагаа явуулах

боломжгүй болно. Бизнесийн төлөвлөгөөнд малын тэжээл үйлдвэрлэх, борлуулах; Бордоо үйлдвэрлэн борлуулах чиглэлийг нэмэх саналтай байна. Та бүхэн саналаа хэлнэ үү.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Энэ зүйтэй санагдаж байна.

Малын тэжээл, бордоо үйлдвэрлэх, борлуулахаас гадна шувууны тэжээл үйлдвэрлэх, борлуулах, дэгдээхэй бойжуулах, борлуулах нь зүйтэй байх.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Тиймээ. Зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За тэгвэл энэ чиглэлүүдийг компанийн дүрмийн 3.3-д нэмэлтээр оруулья. Мөн хүнсний ногоо боловсруулалтыг оруулья. Компанийн дүрмийн 7.8.7-д ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох гэсэн заалт байна. Манай үйл ажиллагаа явагдаагүй байгаа тул цалингийн хэмжээг тогтоогоогүй байсан.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Тиймээ. Бусад компани цалингийн хэмжээг тогтмолоор болон оролцоогоор өгдөг юм байна лээ. Манайх үйл ажиллагаа зогсонги байгаа юм чинь эхний ээлжинд оролцоогоор гээд 1 хурал тутамд 200000 төгрөг байвал ямар вэ?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Үйл ажиллагаа зогсонги юм чинь цалин нь арай өндөр юм шиг санагдаж байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Тиймээ 200000 арай өндөр байна. 100000 төгрөг бол ямар вэ?

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За тэгвэл олонхийн саналаар зөвшөөрсөн тул компанийн дүрмийн 7.8.7-д нэмэлт өөрчлөлт оруулья.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Компанийн дүрмийн 7.32-д ТУЗ-ийн хурлыг 3 сард 1 удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно гэсэн заалт байна. Энийг шинэчилмээр санагдаж байна. Яагаад гэвэл манай компанийн үйл ажиллагаа тогтмол биш тул яадаж хагас жил тутамд 1 удаа хуралдуулах саналтай байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Энэ их зөв санал байна. Тэгвэл ТУЗ-ийг хагас, бүтэн жилээр хуралдуулан шаардлагатай тохиолдолд нэмэлт хурал зарлан хуралдуулж болно гэсэн нэмэлт өөрчлөлт оруулья. Мөн ТУЗ-аас олгосон эрх мэдлийн хүрээнд компанийг төлөөлж гадаад, дотоодын байгууллага, хувь хүмүүстэй шууд харилцаж, тэдэнтэй гэрээ, хэлэлцээр хийх гэсэн заалт нэмэх шаардлагатай юм шиг санагдаж байна. Гадаад, дотоодын байгууллагатай гэрээ хэлцэл хийх гэхээр эрх нь олгогдоогүй байгаад байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Тиймээ. Компанийн дүрмээр зааж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Зөвшөөрч байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За тэгвэл бүгд зөвшөөрч байгаа бол шийдвэр гаргая. За дараагийн нэг санал бол миний хувьд компанийн “Бөхөг” нэрийг “Шувуун фабрик” ХК болговол ямар вэ? Компанийн бүтээгдэхүүний нэрийг “Бөхөг” өндөг, “Бөхөг” тахианы мах гэх мэт нэрлэвэл ямар вэ? Гэсэн саналтай байна. Судлаад нэрээ өөрчилъе.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Би арай залуу хүн болохоор тэр үү Шувуун фабрик нэрээр нь мэдэхгүй Бөхөг гэдэг нэрээр нь л мэддэг. Шувуун фабрик гэдэг нь энэ хавийн газар нутгийг нэрлэдэг юм шиг санагддаг.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Одоо бол Туул тосгон гэдэг нэртэй болсон. Миний хувьд хүмүүст Бөхөг гэхээр сайн мэддэггүй юм шиг санагдсан. Шувуун фабрик гэхээр аан мэднэ мэднэ гэдэг. Тэгэхээр олны танил болсон газар усны нэршил болчихсон нэрээр соливол ямар вэ гэсэн юм. Бусад газрууд НВЦ компанийн Баян өндөг

гэдэг шиг л Шувуун фабрик компаний Бөхөг өндөг гэвэл олон хүнд хүрэх юм шиг санагдаж байна. Хуучин, шинэ нэрээр нь аль алийг нь хүн сонсоод мэдэх боломжтой.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Нэр солих асуудал бичиг цаасны хүрээнд амархан, харин хүмүүст хүрэх тал дээр ямар байхыг судалгаа хийж байж сольсон дээр байх.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Хувьцаат компанийн нэр солих асуудал болдог эсэхийг би бас сайн мэдэхгүй байна.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Болно.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: ХХК-тай адилхан сольж болдог юм байна лээ.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Хөрөнгө оруулагчдад бас Бөхөг нэрээр өгсөн. Хэрэв хөрөнгө оруулалт хийхгүй гэвэл дараа дараагийн компанид материалаа өгөхөөс өмнө сольж болох байх.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Их том хэмжээний цар хүрээ ихтэй судалгаа хийх юм байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: За тэгвэл судалгаа хийж байж шийдвэрлэе. За дараагийн асуудал болох цэвэр бохир усны байгууламжаа бусад байгууллагад ашиглуулж байгаа байдлыг зогсоох хэрэгтэй байх. Байгууллагын өмчийг нийтийн хэрэгцээнд ашиглаад байх болохгүй.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Бид шаардлага, албан бичиг хүргүүлдэг. Засаг захиргаа нь за одоохон шийднэ гэх мэт цаг хожоод л өдийг хүрсэн.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Албан ёсны шаардлага өгч байсан уу?

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Өгч байсан.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Манай компанийн балансад байдаг уу?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Байдаг. Гэхдээ усны байгууламж маань тэнд нийтийнх болчихоод байна.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Төлбөр мөнгийг нь хэн нь төлдөг вэ?

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Хэрэглэж байгаа байгууллагууд нь төлдөг. Манайд бол ямар нэгэн төлбөр хураамж төлдөггүй.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Ерөнхийдөө бол одоо үйл ажиллагааг нь зогсоолоо манайх өмчөө авлаа гэхэд танай байгууллага нийгмийн хариуцлагын хүрээнд тосгоны мааны усыг хаахгүй ашиглуулж байгаачээ л гэдэг. Энд чинь элэгдэл хорогдол гэж юм бас байна.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Одоо хурлаар тогтоол гаргаад тэгээд хугацаа заагаад тэр хугацаандаа хаавал яасан юм бэ?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Тэр нь зөв байх. 5 сарын 15 ч юм уу он сар хугацаа заах нь зөв байх.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Тогтоол нь өмчийг буцаан авах гэж гарах уу?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Тэгье.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Гэхдээ хорооны засаг даргад мэдэгдэл өгнө биз дээ.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Тэгнэ. ХУД-ийн засаг даргад бас өгье.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Бичгээр засаг даргад өгөхөд бичиг нь тэндээ л байгаад байдаг ард иргэд нь мэдэхгүй байх магадлалтай. Тиймээс Бөхөг компаний өмч гэдэг самбар хийвэл ямар вэ?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Ер нь бол манай компаний хашаатай. Ард иргэдэд мэдэгдэх үүрэг нь компанид биш засаг даргад байдаг юм байна лээ. Төрийн байгууллага ард иргэдийг ая тухтай амьдруулах орчиноор хангах ёстой. Магадгүй манай компанитай хэлцэл хийж болно шүү дээ.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Тийм шүү. Уул нь манай компани мөнгийг нь авбал хэн хэндээ амар юмсан.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Ерөнхийдөө ТУЗ-д үүрэг даалгавраар өгвөл яасан юм бэ? Шийдвэрээ ТУЗ-д гаргаж өгье.

Хувьцаа эзэмшигч Д.Эрдэнэцогт: Зөвшөөрч байна. Яаралтай хөөцөлдөх хэрэгтэй.

Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал Ц.Ганцэцэг: Тэгье.

БиДиСек-ыг төлөөлж итгэмжлэлээр С.Дамдинсүрэн: Миний хувьд байгууллагаа төлөөлж ирсэн. Манай байгууллагын нэр дээр танай компаний 7143 ширхэг хувьцаа эзэмшдэг. Энийг нэг бүрийн үнийг 4100 төгрөгөөр зарах санал сонирхолтой байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Манай компанийн хувьд одоогийн үйл ажиллагаа бүрэн зогссон. Компанийн зүгээс нэмж хувьцаа худалдаж авах боломжгүй байна. Манай хувьцаа эзэмшигчид бас сонирхож болно шүү.

БиДиСек-ыг төлөөлж итгэмжлэлээр С.Дамдинсүрэн: Компанийн үйл ажиллагаа бүрэн зогссон байгаа юм уу? Хэзээ хөрөнгө оруулалт нь орж ирэх төлөвтэй байгаа вэ?

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Үйл ажиллагаа бүрэн зогсоод 5 жил болж байна. Яг одоогийн байдлаар хөрөнгө оруулалт хийх гээд гадаадын байгууллага судлах түвшинд явж байгаа. Яг хэзээ хөрөнгө оруулахыг бид хэлж мэдэхгүй байна.

Хувьцаа эзэмшигч, хурлын дарга Ц.Чанцал: Хувьцаа эзэмшигчдийн саналыг авлаа, хэлэлцэх асуудал дууслаа. Хурлаар шийдвэрлэсэн асуудал тус бүрээр саналын тоог **ТООЛЛОГЫН КОМИСС** нэгтгэж, шийдвэрийг томъёолбол:

Нэгдүгээр асуудал:

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2016-2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд тус компани өнгөрсөн онд үйл ажиллагааг эхлүүлэх санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхээр төсөл боловсруулан, техник технологийн шинэчлэлийн судалгааг хийж, бусдад төлөх өр төлбөрийг төлөх талаар тодорхой ажлуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ажилласныг тэмдэглэж “Бөхөг” Хувьцаат компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

Хоёрдугаар асуудал:

1. Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг **Хавсралт**-аар баталсугай;

2. Энэ тогтоол, тогтоолын хавсралтаар баталсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Норов/-д үүрэг болгосугай.

Гуравдугаар асуудал:

1. “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Магсар овогтой Норовыг үүрэгт ажлаас нь чөлөөлсүгэй.

2. “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Цогт овогтой Чанцалыг томилон ажиллуулах саналыг Төлөөлөн Удирдах Зөвлөлд хүргүүлсүгэй.

Дөрөвдүгээр асуудал:

1. Компанийн үйл ажиллагааг өргөжүүлэх, шинэ технологи нэвтрүүлэхтэй холбоотой санхүүгийн эх үүсвэрийг бий болгох зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчидтай их хэмжээний хэлцэл хийх эрхийг ТУЗ-д олгосугай.

2. Их хэмжээний хэлцэл хийхтэй холбоотой ажлыг эрхлэн гүйцэтгэх, хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /М.Норов/, Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-т тус тус хариуцуулан даалгасугай.

3. Их хэмжээний хэлцэл, түүнтэй холбогдох бүртгэл, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийг хэрэгжүүлж, зохих бичиг баримтыг “Санхүүгийн зохицуулах хороо”, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК болон бусад холбогдох газруудад хуульд заасан

хугацаанд, зохих журмын дагуу бүртгүүлэх, хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

Тавдугаар асуудал:

1. “Бөхөг” Хувьцаат компанийн 2017 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайланг судлан үзсэний үндсэн дээр Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 03-р сарын 06-ний өдрийн №02 тоот тогтоолыг баталсугай.

Зургаадугаар асуудал:

1. “Бөхөг” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтүүдийг Хавсралт 1 ёсоор баталсугай.

2. Компанийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа дагаж мөрдсүгэй

1. “Бөхөг” ХК-ийн өмчийг тооллого хийж, коджуулах ажлыг зохион байгуулсугай.
2. Цэвэр, бохир усны байгууламжид үйл ажиллагаа явуулж буй холбогдох байгууллагын үйл ажиллагааг 2018 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөр тасалбар болгон зогсоож чөлөөлөх тухай мэдэгдлийг хүргүүлсүгэй.
3. Өмчийн маргаантай байгаа гал унтраах ангийн ашиглаж буй компаний байрыг чөлүүлэх ажлыг хуулийн дагуу гүйцэтгэж компаний өмчид бүртгэсүгэй.
4. Өмчийн өөрчлөлтийг санхүүгийн тайланд тусган ажиллахыг нягтлан бодогч (Р.Дархижав)-д даалгасугай.
5. Санхүүгийн тайланг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хуулийн хугацаанд хүргүүлэхийг нягтлан бодогч (Р.Дархижав)-д даалгасугай.
6. Тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Ганцэцэг)-д үүрэг болгосугай.
7. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавин ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (М.Норов)-д үүрэг болгосугай.

1. Бөхөг ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалинг оролцоонд үндэслэсэн цалингаар тогтоосугай.
2. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг Хавсралт 1 ёсоор тогтоосугай.
3. ТУЗ-ийн гишүүдийн оролцооны цалинг Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон оролцоонд үндэслэн, хагас жилд нэг удаа олгосугай.

За хурал үүгээр дуусч байна. Хурлын үйл ажиллагаанд идэвхитэй оролцсон та бүхэндээ баярлалаа.

Ойгоо багдтай :

/Ц.Чанцал/

Ойгоо багдтай :

/М.Билгүүнзаяа/